

**МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр

№01

Улаанбаатар хот

“Монгол Даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60, 64, 65 дугаар зүйл болон 62 дугаар зүйлийн 62.1 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тоот тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 2.2 дахь заалт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 12:00 цагаас Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 4 дүгээр хороо, Сөүлийн гудамж-23, Түшиг төвийн 2 давхрын 211 тоот хурлын танхимд хуралдав.

Хурлын дарга Ч.Одонгэрэл: “Монгол Даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож байгаа та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье!

2026 оны 3 дугаар сарын 20-ны өдөр Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах тухай” 26/12 дугаартай шийдвэрийг компанийн тухай хуульд нийцүүлэн гаргасан.

Хуралд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, хурлыг зохион байгуулах комиссын дарга Т.Цацрал, Тооллогын комиссын дарга Х.Доржзовд, гишүүн М.Алтангадас, “Монгол Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал Э.Алтанзул, Хувьцаа эзэмшигч Милленниум Секьюритис Менежмент Лимитед компанийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Л.Таня, хувьцаа эзэмшигч Ж.Пүрэвсүрэн, хувьцаа эзэмшигч Ж.Энхтунгалаг, Компанийн Ерөнхий нягтлан бодогч Ч.Бат-Өлзий нар оролцож байна. Тооллогын комисс хувьцаа эзэмшигчдэд хурлын ирцийг танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга Х.Доржзовд: “Монгол Даатгал” ХК нь нийт 64,132,341 ширхэг хувьцаатай, нийт 287 хувьцаа эзэмшигч байна. Үүнээс өнөөдрийн хуралд “Милленниум Секьюритис Менежмент Лимитед” компани 63,997,215 ширхэг хувьцаатай, Ж.Пүрэвсүрэн 87 ширхэг, Ж.Энхтунгалаг 10 ширхэг хувьцаатай байна. Нийт саналын эрхтэй 63,997,312 ширхэг хувьцаатай буюу 99,7 хувийн ирцтэй байна.

“Компанийн тухай хууль”-ийн 69.1 дэх заалтыг үндэслэн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцох тухай Тооллогын комиссын анхдугаар тогтоолыг танилцуулья.

Тооллогын комиссын дарга Х.Доржзовд тооллогын комиссын 26/01 тоот тогтоолыг уншиж танилцуулав.

Хурлын дарга Ч.Одонгэрэл: Хурлын ирц хүрсэн учраас хурлаа нээж, Монгол Даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн тогтоолыг болон уг тогтоолоор баталсан хурлын дэгийг танилцуулья.

ТУЗ-ийн тогтоолыг танилцуулав.

Хурлын дарга Ч.Одонгэрэл: Хурлаар хэлэлцэх асуудлуудын материалыг та бүхэнд урьдчилан хүргүүлсэн. Хурлын дэгийн дагуу эхний танилцуулах асуудал бол Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, түүний талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж, батлах тухай асуудлыг танилцуулна уу хэмээн Гүйцэтгэх захирал Э.Алтанзулыг урьж байна.

Гүйцэтгэх захирал Э.Алтанзул: Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулав.

Хурлын дарга Ч.Одонгэрэл: Гүйцэтгэх захирал Э.Алтанзул танд баярлалаа!
Хувьцаа эзэмшигчдээс асуух асуулт байна уу?

Хувьцаа эзэмшигч Ж.Пүрэвсүрэн: Санхүүгийн тайлангаас тодруулах зүйл байна. Аудитладсан тайланд дурдсан "Тусгай нөөц санг Санхүүгийн зохицуулах хороо /СЗХ/-ны шаардлагад нийцүүлэн байгуулсан бөгөөд СЗХ-той зөвшилцсөний үндсэн дээр Хувьцаа эзэмшигчдэд олгох боломжтой" гэдэг нь ногдол ашгийг хэлж байгаа юу?

Ерөнхий нягтлан бодогч Ч.Бат-Өлзий: Тийм ээ. СЗХ олгох боломжтой гэвэл боломжтой гэсэн үг.

Өөр асуулт гарсангүй.

Хурлын дарга Ч.Одонгэрэл: Дараагийн танилцуулах асуудал бол Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдийг танилцуулахаар байна.

Хурлын дарга тус асуудлыг танилцуулав.

Хувьцаа эзэмшигч Ж.Пүрэвсүрэн: Нэр дэвшигчдийн компанийн хувьцаа эзэмшлийн талаар мэдээлэл өгөөч.

Тус асуудлаар ТУЗ-ийн НБД Т.Цацрал мэдээлэл өгөв.

Өөр асуулт гарсангүй.

Хурлын дарга Ч.Одонгэрэл: Дараагийн танилцуулах асуудал бол 2026 оны ТУЗ-ийн зардлын төсвийн төслийг танилцуулахаар байна.

ТУЗ-ийн НБД Т.Цацрал: Компанийн 2026 оны ТУЗ-ийн зардлын төсвийн төслийг танилцуулав.

Хуралд оролцогчдоос асуулт гарсангүй.

Хурлын дарга Ч.Одонгэрэл: Дараагийн буюу сүүлийн танилцуулах асуудал бол Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал байна.

Гүйцэтгэх захирал Э.Алтанзул: Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг танилцуулав.

Хуралд оролцогчдоос асуулт гарсангүй.

Хурлын дарга Ч.Одонгэрэл: Хурлын дэгийн дагуу та бүхэнд хэлэлцэж буй асуудлууд болон хурлын материалтай холбогдсон асуулт байна уу?

Хуралд оролцогчдоос асуулт гарсангүй.

Хурлын дарга Ч.Одонгэрэл: Хуралд оролцогчдоос асуулт гараагүй учир хурлаа үргэлжлүүлэн тооллогын комиссын дарга Х.Доржзовд санал тоолох ажил дууссан бол саналын дүнг танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга Х.Доржзовд: Санал тоолох ажил дууслаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын дүн дараах байдалтай байна. Нийт 63,997,312 саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид саналаа өгч хэлэлцсэн бүх асуудлаар 100 хувийн саналаар зөвшөөрсөн байна. Татгалзсан санал байхгүй тул баталсанд тооцов.

Тооллогын комиссын дарга Х.Доржзовд тооллогын комиссын 26/02 тоот тогтоолыг уншиж танилцуулав.

Хурлын дарга Ч.Одонгэрэл: Тооллогын комисс шийдвэрээ танилцууллаа. Үүнийг үндэслэж хурлаас гарах шийдэрүүдийг танилцуулъя.

Нэгдүгээр асуудлаар: Компанийн тухай хуулийн 62.1.9, 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын 26/02 тоот тогтоолыг үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

“Монгол Даатгал” ХК-ийн 2025 оны компанийн санхүү, үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

Хоёрдугаар асуудлаар: Компанийн тухай хуулийн 62.1.7, 77.4, 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын 26/02 тоот тогтоолыг үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

“Монгол Даатгал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгож, Дараах 6 нэр дэвшигчийг ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгосугай:

1. Громов Сергей Борисович
2. Ишхүүгийн Дариймаа
3. Жамбалын Эрдэнэтуяа
4. Лизунова Таня
5. Огай Наталья Юрьевна
6. Энхсайханы Алтанзул

Дараах 3 нэр дэвшигчийг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгосугай:

1. Батмөнхийн Мөнхзул
2. Настын Тэмүүлэн
3. Дамдингийн Болормаа

Гуравдугаар асуудлаар: Компанийн тухай хуулийн 62.1.13, 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын 26/02 тоот тогтоолыг үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

ТУЗ-ийн 2026 оны төсвийг тус тогтоолын хавсралтаар баталсугай. Батлагдсан төсвийг мөрдөн, ТУЗ-ийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулан, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг удирдан чиглүүлж ажиллахыг ТУЗ /Громов С.Б./-д үүрэг болгосугай.

Дөрөвдүгээр асуудлаар: Компанийн тухай хуулийн 62.1.1, 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын 26/02 тоот тогтоолыг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ НЬ:

Монгол Даатгал" ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.22, 7.45, 7.52, 7.53, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт тус тус өөрчлөлт оруулж, 7 дугаар зүйлийн 7.32.23 дахь хэсэгт хавсралтад зааснаар нэмэлт оруулсугай.

Дээрх 4 тогтоолыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан болохыг та бүхэнд мэдэгдлээ. Хувьцаа эзэмшигчдийн хуралдаа идэвхтэй оролцсон хувьцаа эзэмшигчдэдээ баярлалаа! Хуралтай холбоотой сайжруулах, анхаарах зүйлс байвал хувьцаа эзэмшигчдийн хурлын комиссын дарга Т.Цацралд хандах, компанийн вэбсайтаар дамжуулан саналаа илгээх, мэдээлэл авахад нээлттэй. Хувьцаа эзэмшигчдийн хуралдаа идэвхтэй оролцож байгаад талархснаа илэрхийлье.

Өнөөдрийн хурал хаасныг мэдэгдье.

Хурал 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 13:45 минутад өндөрлөв.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ТАНИЛЦСАН ХУРЛЫН ДАРГА:



Т.Цацрал

Ч.Одонгэрэл